

ТАНИЛЦУУЛГА

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийн талаар

“Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” ХХЗХ-ны 2018 оны 17 дугаар тогтоол”

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан захиргааны хэм хэмжээний актуудад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн зарим хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх шаардлага үүсээд байна.

Дээрх үндэслэлээр Харилцаа холбооны зохицуулах хорооны 2018 оны 17 дугаар “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулав. Үүнд:

1. Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.10 дахь заалтыг өөрчлөн найруулсан тул энэхүү заалтыг тогтоолын тэмдэглэх хэсгийн үндэслэл болгосон заалтаас хасах,

2. Радио долгионы тухай хуулийн 5¹.1.2-т Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих бүрэн эрхтэй” гэж заасан тул хуулиар эрх олгосон дээрх заалтыг тогтоолын үндэслэл хэсэгт нэмж оруулахаар тусгасан болно.

---oOo---

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... сарын ...

Дугаар...

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны “Радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тогтоож, батлах тухай” 2018 оны 17 дугаар тогтоолын тэмдэглэх хэсгийн үндэслэл болгосон заалтад дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1.1. “Радио долгионы тухай хуулийн 3.1.4” гэсний дараа “5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}” гэж нэмэх,

1.2. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “9.1.10” гэснийг хасах.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /...../-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД:

.....

.....

.....